

ХАН ҮНДЭСТНИЙ “ГУРАВ БА НЭГ” ТЭНГЭРИЙН ҮЗЛИЙН ТУХАЙД

*Ким Жо Хо**

Бидэнд нэгэнт мэдэгдэхүүн болсон хан үндэстний “гурав ба нэг” тэнгэрийн үзэл түүний нэр, үгийн гарвал, утга судлал талаас нь товч атугай тайлбар хийе.

Энд өгүүлэн буй хан үндэстний “хан” хэмээх нэрийн дуудлага “тэнгэр”, мөн “нэг” лүгээ утга дүйх бөгөөс тухайлбал “хан” орон, “хан” улс, “хан” үндэстэн хэмээх нь тэнгэрийн орон, тэнгэрийн улс, тэнгэрийн үндэстэн түүний язгуур гарвал нь тэнгэр язгууртан лугаа нэрийн утга судлал үүдэл ийнхүү гарсан бүлгээ.

Мөнхүү “гурав ба нэг” хэмээх нэрийн гарвал түүний утга судлал “нэг” тэнгэрийн гурван зарчим буюу хан үндэстний тэнгэрийн үзэл лүгээ шүтэлцээтэй. Тэрээр “нэг” тэнгэрийн үзэлд хан үндэстний, үндэстний язгуурын ухамсар бүрэлдэн төлөвшиж ер ертөнц дахины үүсэл, тэнгэр, эрхэс гариг, огторгуйн хамаг юмс болон хүн төрөлхтний язгуур гарвал, түүний оршин ахуй орон зай, цаг, жам ёсны зүй тогтол хөгжил-хөдөлгөөн, хомсдох-арвидах, мөхөх-сэргэх гэх нэг нь нөгөөгөө нөхөн тэтгэх юмсыг “нэгээс эхлэхүй, харин “нэг” нь эхлэл үгүй “нэг” бөгөөд эл эхлэл үгүй “нэг” эхлэл төгсгөл үгүй болохын хувьд эхлэлийн “нэг”-ээс хамаг юмс үүдэн үүсэх төгсгөл үгүй, зогсолт үгүй, тасралт үгүй зарчимд тулгуурлан тайлбарлаж ирсэн болой.

Бидний дээр өгүүлсэнчилэн дээд тэнгэрийн сургаал огторгуйн үүсэл, хувьсал өөрчлөлтийн зарчим, зүй тогтлыг “нэг”-ээс гурав руу шилжин “гурав ба нэг” тэнгэрийн үзлийн “гурав” нь “нэг” рүү нэгдэх зарчим бөгөөс хан үндэстний эртний язгуурын тэнгэрийн үзэл “нэг”-ээс “гурав” руу түгэн, харин “гурав”-аас “нэг” рүү эргэж буй “нэг ба гурав”, “гурав ба нэг” гэдэг зарчмыг агуулсан тэнгэрийн үзэл юм.

Тухайлбал, “нэг ба гурав”, “гурав ба нэг” зарчмыг нэг үгээр хэлбэл “бие нь нэг, утга судлахуун нь гурав” гээд “гурав ба нэг” зарчим гэх бөгөөд үүн дээр тулгуурлан тайлбарлаж буй тэнгэрийн үзлийг гурван тэнгэр нэг цогц гэдэг.

Чингэхүл “Дээд тэнгэрийн судар”, “Гурав ба нэг” тэнгэрийн сургаал түүний уг язгуурын гол эх сурвалж бичиг бөгөөс харин бусад судруудын “гурав ба нэг” зарчимтай ижил төсөөтэй хэсгүүд олонтой үзэгдэж байдаг.

Ялангуяа “Тэнгэрийн бичээс”, “Тэнгэрийн зарчим”, “Гурван нэгдлийн судар”, “Дангуны судар”, “Гурван тэнгэр таван бурханы

* Ким Жо Хо - докторант, (БНСУ)

бичээс” зэрэг сударт “гурав ба нэг” зарчмын гурван тэнгэр, нэг цогц тэнгэрийн үзлийн уялдаа холбоог тайлбарласан байх болно.

“Тэнгэрийн бичээс” нэртэд, тэнгэр нь зохицол, гэгээрэл, удирдах гэсэн мөн чанартай ахул, зохицол, гэгээрэл, удирдах “гурав ба гэг” – ийн зарчмаар тэнгэрийн үйлийг тайлбарлах үүнд, “Зохицлын эзэн хан ин тэнгэрийн оронд орших, асар буянаар түмэн бодис юмсыг бүтээсэн” гэх. “Гэгээрлийн эзэн хан үн их мөрийг бүтээн асар гэгээрлээр мунхаг хүмүүсийг гийгүүлж чадсан” гэдэг. “Удирдахын эзэн хан гөм таван үйлийг дааж хүнийг хүн болгох, улсыг анхлан буй болгох, 3 арш ба 4 сүнсэнд зарлиг буулгаж хүмүүний 366 үйлийг хариуцан даана болтой”.

Харин нэг зүйлийг анхааран тэмдэглэхэд тэнгэрийг огторгуй ба хүн, түүнийг зохицуулсан, гэгээрүүлсэн, удирдаж байна гэж өгүүлэх бөгөөс христийн шашны бүтээлд зохицол, гэгээрүүлэх, удирдах үйлийн тухайд тусгалаа олоочгүй дурдаагүй байх жишээтэй.

Тэнгэрийн зарчим нэртэд; тэнгэр нэр хан-им, хан-үн, хан-гөм гэж байх бөгөөс үүнээс хан-им тэнгэр зохицлын суудалд суух, хан-үн тэнгэр гэгээрлийн суудалд суух, хан-гөм тэнгэр удирдахын суудалд суужээ.

Чингэхүл хан-үл тэнгэрт үүнээс илүү суудал байх үгүй бөгөөс түмэн бодис юмс үүнээс илүү эхлэл байхгүй харин хүнд ч үүнээс илүү эхлэл байх үгүй гэдэг. Хуваавал гурав, нэгдвэл нэг ба гурваар тэнгэрийн суудал шийдэгдэнэ гэж үзэх бий.

Тэнгэрийн суудал нэг, гурваар хуваагдах нь ямар учиртай юм бэ? гэвэл “Нэг” нь нэгдэх, гурав нь хуваагдахын утгатай бөгөөс энэ нь цогц нэг, судлахуун нь гурав гэсэн утгатай.

Тэнгэрийн мөр дүрсгүй дүрсээр илрэх, үг үгүй үгээр илэрхийлнэ. Төрөх үгүй, гэгээрэл үгүй, үүсэх үгүй тиймээс ертөнц өргөжин тэлж хөдөлгөөнөөр өөрчлөгдөх, түмэн бодис улам бүр тэлэх хүн төрөлхтөн үүнийг олж мэдэрч буяныг хүртэнэ.

Тухайлбал, хан-үл нь хан өл ним болох учраас хүн харин хан-гөм ним болно гэж тайлбарлах болсон. Чухамдаа тэнгэр хүн хан-өл хүнд хан-гим, хан-өлд хан үний гурван суудал, мөн ханбэ тэнгэрээс эцэг, багш, хааны гурван суудал байх бөгөөс хоёрдмол утга байхгүй.

Тэнгэрийн зүй нь “гурав ба нэг” бөгөөс “нэг” нь байгаад гурав байхгүй бол энэ нь судлахуун байхгүй, гурав байгаад нэг байхгүй бол энэ нь цогц байхгүй.

Иймээс “нэг” нь “гурвын” цогц болж, “гурав” тэр “нэгийн” судлахуун болно. Тэнгэр газрын шалтгаан нь нэг бөгөөд гурваар л өөрчлөгдөнө. Энэ нь зохицол, гэгээрэл, удирдах эл ухагдахууны аль нэг нь дутваас тэнгэрийн үйл үл бүтнэ. Нэг нь өөрчлөгдөн гурав болоод

гурав үнэн рүү эргэн нэг болсоноор тэнгэр лүгээ нэгдэнэ. Үүнийг тэнгэрийн гэгээрэл гэж үздэг байгаа.

Гурван нэгдлийн сургаал гол үзэл нь “нэг”-ээс “гурав” болох бөгөөд үнэн, төөрөгдөл хуваагдана. Харин “гурав” нэг болоод төөрөгдөл ба үнэний замд хуваагдана гэсэн үзлийг тайлбарладаг.

“Тэнгэр нь хан үзлийн эзэн буюу их буян, их билиг, их чадал, бат бөхийн шинж агуулсан дүрсгүйг бүтээгч, үг үгүйг айлдагч агуу их тэнгэр минь. Зохицол хэмээх эцгийн мөр, гэгээрэл болох багшийн мөр, удирдах хааны мөр байдаг” гээд эцгийн мөр нь хан-им-ээс эхлэн, багшийн мөр хан-үнээс эхлэн, хааны мөр хан-гөмөөс эхлэнэ. Энэ гурав мөр хүн байх бөгөөд гагцхүү хүн эхлэлтэй, тэнгэр эхлэл үгүй болох учирт гурван тэнгэрийн номлол гэж ухаарч байжээ.

Дээр өгүүлэн буй гурван нэгдлийн сургаалд ой ухааныг их ухаан, дунд, бага гэж гурав хуваагаад их ухаан зан ааштай нийлэх, дунд ухаан амь насыг мэдэх, бага ухаан сүр сүлдийг хамгаална.

Ер нь зан аашийн хэлбэр нь дугуй, амь насных дөрвөлжин, сүр сүлд гурвалжин хэлбэртэй бөгөөд эдгээрийг гурван ухаан гэнэ. Ухаан гурван туйлын хэлбэрт дулдуйдан гаднах байдал дугуй, доторх нь хоосон байх нь хан-үлийн дээдийг бүрдүүлсэн тэгш гадаргуу нь газрын тэгшийг үүдэн, дээд талынх нь тэгш тоо, доод талын сондгой тоо хүний байдлыг илэрхийлнэ.

Ухаан үнэн рүү эргэн ороод чулуу гурав лугаа адил ба түүнээс өгсөн орохын төгсгөлд нэг л орон зай байна. Үүнийг гурван ухаан хэмээнэ болой. Чингэхүл дээр дурдсанаар хүнд байх гурван ёс зүй энэрэл асрал, ёс жудаг, зам мөр үүнээс энэрэл асарлын ёс зүйг тэнгэрээс, ёс жудгийг хүнээс, зам мөрийн ёс зүйг хан-үл буюу хүнээс олж авна.

Тебек ил-сагийн “Бага мөрийн сударт”-т дээд тэнгэрийн бичээс “гурав ба нэг” тэнгэрийн агуулгаас бүрдсэн найман зүйл багтжээ.

Ерөнхийдөө эл судруудын үзэл санаа адил бөгөөд гурван тэнгэрийн тухай тайлбар нь На-чөлийн бичсэн Шинридежены агуулгатай адил гурван тэнгэр таван бурханы бичээсийн агуулгаас эшлэл татваас “Корёгийн найман үзлийн бичээсийн гурван тэнгэрийн тайлбарыг өгүүлнэ”.

Дээд орны эзнийг нэг буюу хан тэнгэр гэх бөгөөс зохицлыг удирдан, үнэмлэхүй дээдийн дээд хүч чадалтай, дүрс үгүй дүрсээр илрэн түмэн бодис тус бүрийн зан аашийг дамжуулна гэж үздэг их үнэний бие хэмээнэ.

Доод орны эзнийг “нэг” газар гээд гэгээрлийг удирдан, цорын ганц үнэмлэхүй сайны зарчимтай тул түмэн бодис тус бүрийн амь насыг мэдэх тул үүнийг ариун их бие хэмээнэ.

Дунд орны эзнийг саран гээд удирдах чадалтай ба хэмжээлшгүй буяныг хураасан бөгөөс үг үгүй хувиран түмэн бодисын сүр сүлдийг хамгаалахын учирт үүнийг их чадалтаны бие хэмээнэ.

Чингэхүл тэнгэр эзэн бөгөөд тэнгэр бурхан тус, тусдаа оршиж байгаа бус харин үйл, үйлдэл нь гурван бурхан болно гэж үздэг байгаа.

Дээр өгүүлэн буй гурван тэнгэрийн үйлдэл болох зохицол, гэгээрэл, удирдахын утга илэрхийлэл нь ерөнхийдөө Шинридежен ба Шинсагитэй адил бөгөөд гурван тэнгэр “дүрсгүй дүрсээр илрэх, үг үгүй ярих” гэсэн агуулгаар “гурван” тэнгэрийн язгуур нь “нэг”, үйл нь “гурав” гэсэн “гурван тэнгэр” “нэг цогц”-ын тэнгэрийн дүрийг нэгэн адил илэрхийлсэн бөгөөс эдгээрх судрууд Нэг л үзэл санаанаас бүрдсэн гэдгийг харуулж байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй юмаа.

Гурван бурханы тэнгэр нэг, газар нэг, сар нэг гэсэн хэллэгт сар нэгийг хүн нэгээр сольсон нь дээд тэнгэрийн сургаалтай адил болой.

Гурван бурхан нэг цогцын тэнгэрийн үзэл гэдэг нь “нэг”-ийг цогц хэмээн “гурвыг” ин, үн, гам буюу шалтгаан, үр, дагаврыг судлахуун болгодог тэнгэрийн үзэл юм.

Алив судлахуун илрэхдээ, шалтгаан, үр, дагавар болж эцэстээ “Нэг” болох цогц руу эргэн одох, бие нь Нэг, судлахуун нь Гурав болдог Нэг цогц, Гурван судлахууны тэнгэрийн зарчмыг тайлбарлах болно.

Өөрөөр хэлбэл, “нэг ба гурав”, “гурав ба нэг”-ийн зарчим нь тэнгэр (эзэн) болно. Тухайлбал, “нэг боловч гурав”, “гурав ба нэг”-ийн зарчмаар гурван тэнгэр, нэг цогцын тэнгэрийн үзэл тайлбарлагдана.

Тэгэхдээ хан-ин, хан-үн, хан-гөм хэмээх гурван тэнгэр оршиж байна гэсэн үг бус, гурван их судлахуун гэсэн утгатай.

Сайхь “хан”-ыг бие хүн болгогч нь ханним, хан-өлним, хананим юм. Иймд, ин, үн, гөм нь дээд тэнгэрийн дотоод чанарын үйлдлийн оршихүй билээ. Бие нэгийн судлахуун болох ин, үн, гөмийн үйлдэл мөн. Дотоод сэтгэлийн цогц болсон “нэг” нь гадаад чанараар илрэхдээ ин-үн гөмийн үйлдлээр илэрнэ.

Дүгнэлт

3 бурхан 1 цогцын тэнгэрийн үзлийн “гурав ба нэг” зарчим нь хан үндэстний 3 бурхан 1 цогцын бурханы тухай итгэл нь бүдэг бадаг бус, гүн ухааныг сууриа болгон түүгээр үл барам 3-1 зарчмаар бүрдсэн тэнгэрийн үзэл нь өөр байгааг нотлов.

“Хан” гэдгийн цогц нь ин, үн, гөм гэсэн гурван хэрэглэхүүнээр оршиж буй тэнгэр эзэн нь зохицол, гэгээрэл, удирдах гэсэн гурван их хүчээр хүн цаашлаад огторгуйн түмэн бодис үүсгэн, боловсруулан,

бүгээсэн. Эдгээрийг ертөнцийн үүслийн бүлэгт дурдсан байдаг боловч гэгээрэл, удирдахын тухай дурдсан зүйл байдаггүй. Харин бусад шашны тэнгэрийн үзэлтэй харьцуулсан байдаг. Мөн “газар орныг эзэл” гэсэн христийн шашны ариун библи (үүсэл 2 бүлэг 7 зүйл, 1 бүлэг 28 зүйл)-ийг дэлхийн гадаргууг “ки буюу хийморь”-иор хучсан (гурав ба нэг тэнгэрийн бичээс ертөнцийн бүлэг) гэдэгтэй харьцуулсан. Энд өгүүлж буй хийморь нь их хийморь ба сүнсийг хэлж байгаа бөгөөд дэлхий бүхэлдээ хүн болон байгалиас, амьд организм нь бие биендээ харилцан туслан оршин тогтнодог харилцаатай гэдгийг илэрхийлж байна. Иймээс өнөөдөр хурцдаж буй байгаль орчны бохирдол, мөхлийн оронд өөр төсөл санал болгох боломжтой тэнгэрийн үзэл гэж үзэж болно.

АШИГЛАСАН НОМЫН ЖАГСААЛТ

1. Мифы народов мира, Москва ,Советская Энциклопедия, 1987, I, II том
2. Зүүн хойт Азийн түүх ба соёл (хятад хэлээр), Ляосо, 1991.
3. Зүүн хойт Азийн улс түмний түүх (япон хэлээр), 1989, III боть
4. Зүүн хойт Азийн зан заншил, соёлын түүх, ШиЯн, 1992
5. Зүүн хойт Азийн эртний соёл, мөн, 1988
6. Зүүн хойт Азийн утга соёлын түүх, мөн, 1992
7. Нэвтэрхий толь (Үгсийн далай) БНУ, 28 он, Шанхай, I, II боть
8. Орчин үеийн хятад хэлний толь, Бээжин, 1985
9. J.B.Duncan, The Origins of the Chosn Dynasty, Seattle and London, 2000
10. Duk-Whang Kim, A History of Religions in Korea, Daeji Moonwasa, 1988
11. Б.Дулам, Монгол бөөгийн зан үйл, Улаанбаатар, 2002
12. О.Пүрэв, Монгол бөөгийн шашин, Улаанбаатар, 2002
13. Тэнгэрийн ирэлт, Солонгос
14. Д.Цэдэв, Их хятадын оронд бурханы шашны дэлгэрсэн түүх, Улаанбаатар, 1996